

Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2019.06.17-ны өдрийн 07 дугаар хуралдааны шийдвэрээс:

6.1. “Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн бодлого”-ын төслийг хэлэлцээд Монгол Улсын Шадар сайдаар батлуулахаар Шадар сайдын ажлын албанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

6.2. “Онцгой байдлын байгууллагын хүний нөөц, сургалт хөгжлийн хөтөлбөр”-ийн төслийг хэлэлцээд Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулахаар шийдвэрлэв.

6.3. “Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөө 2019-2024 он”-ийн төслийг хэлэлцээд Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулахаар шийдвэрлэв.

6.4. Нөөц төлөвлөлт, удирдлагын нэгдсэн системийн тухай хэлэлцээд замын зураглалыг засварлаж, даргын зөвлөлийн гишүүдээс санал авч нэгтгэн Онцгой байдлын ерөнхий газрын даргад танилцуулахаар шийдвэрлэв.

6.5. Онцгой байдлын албаны гурван үеийн чуулга уулзалтаас гарсан зөвлөмжийн тухай сонсов. Зөвлөмжийг холбогдох газруудад хэрэгжүүлж ажиллах үүрэг өгөв.

6.6. Улаанбаатар хот дахь Улсын нөөцийн салбаруудад явуулсан иж бүрэн шалгалтын дүнг хэлэлцээд Шатахууны нөөцийн салбар 90,4, Хүнсний нөөцийн салбар 91,7, Объект-03 салбар 86,1 хувийн үнэлгээтэйгээр батлав.

6.7. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд Онцгой байдлын байгууллагаас хэрэгжүүлэхээр тусгасан 3 арга хэмжээний хэрэгжилтийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар 80,0 хувийн үнэлгээтэйгээр батлав. Хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хуулийн хугацаанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

6.8. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтэд Онцгой байдлын байгууллагаас хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг хэлэлцээд 90,0 хувьтай батлав. Хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хуулийн хугацаанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

6.9. Онцгой байдлын байгууллагаас хяналтад авсан хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд 2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг хэлэлцээд 87,8 хувьтай батлав. Хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хуулийн хугацаанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

6.10. Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн тухай хэлэлцээд 6 дугаар сарын 30-ны дотор нэмэлт өөрчлөлтийг тусган эхний хагас жилийн биелэлтийн дүнг эцэслэхээр шийдвэрлэв. Биелэлт дутуу ажлын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг холбогдох удирдлагуудад даалгав.

6.11. Онцгой байдлын байгууллагын 15 жилийн ойн баярын бэлтгэл ажилтай холбогдуулан даргын зөвлөлийн гишүүдэд холбогдох үүргийг өгөв.